

**МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ БҮЛЭГ БАРААНЫ
ЖАГСААЛТ**

№	Барааны төрөл	Хууль тогтоомж	Нэвтрүүлэх ялгаа
1	Хориглосон болон зохих зөвшөөрөлгүй озон задлах бодис	Агаарын тухай хуулийн 25.2 ЗГ-ын 2007 оны 95 дугаар тогтоол	оруулах
2	Зохих зөвшөөрөлгүй мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13.1.5, 13.1.7, 13.1.8	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
3	Туршилт, судалгааны ажлаас бусад мод, сөөгний тарьц, суулгац	Ойн тухай хуулийн 29.1.11	оруулах
4	Тамхины бүх төрлийн зар сурталчилгааны материал	Тамхины хяналтын тухай хуулийн 8.2	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
5	Согтууруулах ундааны зар сурталчилгааны материал	Архидан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн 9.3	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
6	Монгол улсад ашиглахыг хориглосон болон зохих зөвшөөрөлгүй химийн хорт болон аюултай бодис	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5.1, 6.4, 15.4 ЗГ-ын 2007 оны 95 дугаар тогтоол	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
7	Ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор аюултай хог хаягдал	Хог хаягдлын тухай хуулийн 17.1	оруулах
8	0.025 мм болон түүнээс бага зузаантай бүх төрлийн нийлэг хальсан уут	Хог хаягдлын тухай хуулийн 18.2	оруулах
9	Зэвсгийн зориулалттай цөмийн материал	Цөмийн энергийн тухай хуулийн 33.2	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
10	Монгол Улсын хуулиар хориглосон болон зохих зөвшөөрөлгүй цөмийн материал, цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологи	Цөмийн энергийн тухай хуулийн 37.2.1, 41.1, 41.2	оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэх
11	Хуурамч эм	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11.1.7	оруулах

12	Зохих зөвшөөрөлгүй эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15.9.3	оруулах
13	Ашиг олох зорилгоор цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэн	Донорын тухай хуулийн 13.1	оруулах, гаргах
14	Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйл	Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 5.3	оруулах, гаргах
15	Судалгаа, шинжилгээний зориулалттайгаас бусад этилийн спирт	УИХ-ын 05 дугаар тогтоол ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоол	оруулах
16	Пиво ундааны хаягдал лаазнаас бусад хаягдал хар болон өнгөт төмөрлөг /ширэм, төмөр, ган, зэс, гууль, хөнгөн цагаан, тэдгээрийн хайлш/, цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй хар болон өнгөт төмөрлөг, зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг, бүтээгдэхүүн	УИХ-ын 05 дугаар тогтоол	гаргах
17	Судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын 1 дүгээр хавсралтад нэр заагдсан амьтан, ургамал	зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц	оруулах, гаргах
18	Зохих зөвшөөрөлгүй ургамал, ургамлын олон наст үндэс, үндэслэг иш, булцуу	Байгалийн ургамлын тухай хуулийн 17.1, 17.3	гаргах
19	Судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйл	Байгалийн ургамлын тухай хуулийн 17.4, 17.5	гаргах
20	Жижиглэн савлагаатай, 25%-аас дээш концентрацитай, хүнсний зориулалттай цууны хүчил (Acetic acid)	ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоол	оруулах
21	Шөрмөсөн чулуу агуулсан бүтээгдэхүүн. Үүнээс: асбест агуулсан тоормосны накладка (Brake pads containing asbestos)	ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоол	оруулах
22	Озоны давхарга, дэлхийн дулааралд сөрөг нөлөө бүхий HCFC-22, HCFC-	Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протокол	оруулах

	1416 бодисоор хөөсөнцөр үйлдвэрлэх тоног төхөөрөмж	ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоол	
23	Пиротехникийн хэрэгсэл	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль ЗГ-ын 2006 оны 149 дүгээр тогтоол	гаргах